

## Ардыг Гэгээрүүлэх хэлтэс

Нийслэл хүрээнд 1921-онд 40 сурагчтай бага сургууль ганц байсан бол улсын их дээд сургууль 6, тусгай мэргэжлийн дунд сургууль 10, ерөнхий боловсролын сургууль 54 байгаад нийт 76.1 мянган хүн суралцаж байна. Соёл урлагын 80 гаруй байгууллага ажиллаж нэг ээлжиндээ 30000 хүнд урлагаар үйлчилж байна. Улаанбаатарын 10000 хүн тутамд эмнэлгийн 169 ор, 33 их эмч ноогдож байна. Сүүлийн 5 жилд яслийн тоо 52 болж 1960 оныхоос хүүхдийн тоо 2 дахин өслөө.

1921 оны 7 дугаар сарын 6-нд Монгол ардын намын Төв хороо, Ардын түр засгийн газар нийслэл хүрээнд ирж, засгийн бүх эрхийг Ардын түр Засгийн газрын мэдэлд авч, Засгийн газрыг өргөтгөн байгуулж, Богдын засгийн газрыг татан буулгаснаас хойш, Нийслэл хотын түр захиргаа байгуулах хүртэл, Нийслэл хүрээний дотоод хэргийг Дотоод яамнаас эрхлэж байв.

1923-1924 онд Ардын төлөөлөгчдийн хурал шат дараалан байгуулагдаж, үүгээр төрийн эрх барих хурал хэмээх Ардын төлөөлөгчдийн байгууллагын шинэ систем тогтжээ.

1923 оны 10 дугаар сарын 5-нд аймгуудыг орших газрын уул, усны нэр, мөн 1 дугаар сард хошуудын хуучин нэрийг халж газар орны нэрээр нэрлэх.

1923-1-13-нд Намын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар нийслэл хотыг сайжруулах тухай хэлэлцэж, хотын захиргаа байгуулах, дүрэм хэмжээг тогтоохоор заажээ.

1924-3-7-нд Засгийн газрын 4-р хурлаар Нийслэл хүрээнд хотын захиргаа байгуулах, түүний түр зуурын дүрмийг баталжээ.

1924 оны 6-р сард засгийн газраас хотын захирагааг өөрийн биеэ даасан төсөв санхүүтэй болгох дүрмийг баталж, уг дүрмийг 1925 оноос эхлэн дагаж явуулахаар тогтоожээ.

1924-8-11-нд Нийслэл хүрээнд хотын захиргаа байгуулжээ.

1924-11-22-нд Улсын анхдугаар их хурлын 11-р тогтоолд хотын захиргаа шинэ тутам байгуулагдсан жинхэнэ хотын захиргаа болгох эрхлэх ажлыг албан газруудаас дараа дараагаар шилжүүлэн өгөхийг заажээ.

1924-11-26-нд улсын анхдугаар Их хурлын 14-р тогтоолоор нийслэл хотын нэрийг Улаанбаатар хот гэж нэрлэхээр тогтоосон.

1925-12-11-нд Засгийн газрын 44-р хурлаар Хотын захиргааг жинхэнэ болгож, дүрмийг улсын бага хурлын тэргүүлэгчдэд явуулан батлуулахаар тогтоожээ.

1925-12-11-нд Улсын 2 дугаар Их хурлаар хотын захиргааны дүрэм дөчин есөн зүйлийг баталсан байна.

Хотын захиргааны гүйцэтгэх газар нь долоон тэргүүлэгчидтэй, түүний дарга, орлогч, нарийн бичгийн дарга нар нь товчоо болон бүрэлдэж байсан бөгөөд хэлтсүүд нь Ерөнхий хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Ардын эрүүлийг сахих хэлтэс, Аж үйлдвэрийн хэлтэс /энэхүү хэлтэст санхүү, аж ахуй, тоо бүртгэх салбарууд хамаарагдаж байв/-тэй байхаар заажээ. Хэлтсүүд нь тухайн үеийн байдлаас өөрчлөгдөж байжээ. Албан газар, цэрэг, үйлдвэрийн хэлтсүүдтэй болсон байна. 1925 онд хотын захиргаа нь 6 хэлтэс, 104 орон тоотой байв.

Улсын 2 дугаар их хурлын шийдвэр болон Засгийн газрын 22 дугаар хурлын 7-р зүйлийг үндэслэн 1926-9-3-нд Засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927-1-1-нээс эхлэн хотын захиргааны газрыг Дотоод яамны харьяанаас өөрчилж тусгай эрхтэй биеэ даасан газар болгохоор заажээ.

БНМАУ-ын 2 дугаар их хурлын 9 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл, Засгийн газрын 22 дугаар тогтоолын 17 дугаар зүйлээр Засгийн газрын комиссын саналыг үндэслэн 1926 оны 9 дүгээр сарын 3-нд Ардын засгийн газрын 35 дугаар хурлын 12 дугаар зүйлээр 1927 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хотын захиргааг Дотоод яамны харьяанаас өөрчилж, тусгай эрхтэй, биеэ даасан газар болгохоор тогтоожээ.

1930-11-14-нд Засгийн газрын 38-р тогтоолын 2-р зүйлээр олон аймаг, хот, сумдын дүрмийг шинэчлэн зохиож ирснийг зөвшөөрч улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраар батлуулахаар тогтоожээ.

1931-3-29-нд Засгийн газрын эрхлэх товчооны 15-р хурлын 3 дугаар зүйлээр Засаг захиргааны газруудад тамга, тэмдэг гэж давхар олгохыг зогсоож ганц тамга олгох, дөрвөлжин маягийг өөрчлөн дугуй хэлбэртэй болгохоор тогтоожээ.

1931-9-7-нд Засгийн газрын 20-р тогтоолын 4-р зүйлээр Төв аймаг, хотын захиргааг нэгтгэх тухай асуудал боловсруулах комиссыг томилсон байна.

1931-9-21-нд УБХ-ын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч, нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, Цагдан сэргийлэх явдлын хэлтэс, улсын хянан байцаах бүртгэлийг Эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1931 оны 9 дугаар сарын 21-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлаар, Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа, нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж, “Улаанбаатар” хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг мөн оны 10 дугаар сарын 1-нд хийхээр тогтоожээ.

1932-8-5 нд Сайд нарын Зөвлөлийн 7-р тогтоолын 11-р зүйлээр Улаанбаатар аймгийн захиргааны зохион байгуулалтыг

- 3-5 хүнтэй тэргүүлэгчид
- Ардыг гэгээрүүлэх хэлтэс
- Бичиг дансны ангитайгаар баталжээ.

1932 онд Сайд нарын Зөвлөлөөс гаргасан тогтоол /хагас/-д дурьдахдаа хүний урьд Сайд нарын Зөвлөлөөс Улаанбаатар хотын захиргааг аж ахуйн талаар биеэ даасан газар болгож ялган байгуулах тухай гаргасан тогтоолд нэмэгдүүлэн тогтоохдоо

- Хотын захиргааг ҮЭ гишүүн, 4 орлогч гишүүнээр байгуулжээ.
- Хотын их хурлыг 1932- 11 -1-нд хийлгэх

- Хотын захиргааны орлого зарлагын төсвийг ялган салгаж 1933 оны 1-р сараас эхлэн явуулах хүртэл хот ба Төв аймаг хоёрын зардлыг нэгтгэсэн төсвөөс гүйцэтгэж байхаар заажээ.

1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.

1933 оны 12 дугаар сарын 29-нд Сайд нарын Зөвлөлийн 42 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл ээр 1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан бөгөөд бүтцийг нь:

Ардын гэгээрэл боловсролын тасаг

Бичиг хэргийн анги

1936 онд Аж Үйлдвэрийн комбинтын дэргэд 7 хороог 21 хоринтойгоор байгуулсан.

1937 оны 2 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, СнЗ-ийн хамтарсан 4/2 дугаар тогтоолоор хотын захиргааг өөрчлөн "Нийслэл Улаанбаатар хотыг захирах яам" болгохоор тогтоосон байна.

1937 оны 2 сарын 5-нд СнЗ-ийн тогтоолоор Улаанбаатар хотын Захиргааны эрхийг өргөтгөн яамны эрх хэмжээнд хүргэж, хотыг захирах яам хэмээн нэрлэж яамны даргыг СнЗ-ийн жинхэнэ гишүүн болгожээ.

1937 оны 05 дугаар сарын 4-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн хурлаар Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталсан ба үндсэн хуулийн дагуу нийслэл хотын яам нь хотын ба хороодын хуралаар батлагдахаар заажээ.

1937 оны 02 дугаар сарын 13-нд Сайд нарын Зөвлөлийн 2 дугаар хурал, Улаанбаатар хотын Тэргүүлэгчдийн 4 дүгээр тогтоолоор 02 зүйлээр Улаанбаатар хотын захиргааг өөрчлөн "Улаанбаатар хотыг захирха яам" болгосон.

1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

Мөн яам нь Сайд нарын /Зөвлөлийн гишүүн байна гээд дотоод байгуулалтыг /

- Ардын соёл боловсруулах хэлтэстэй байна гэжээ.

Тусгай дүрмээр хотын хэмжээнд дээр ажиллах газрууд

- Хотын прокурорууд

- Хотын шүүх таслах газар

- Хотын хоршооны байгууллагууд

- Барьцаалан зээлдүүлэх ламфортын газар

- Хотын доторхи артель, нэгдэл, үйлдвэр, мал эмнэлгийн ажил явуулах удирдлага нөлөөг үзүүлнэ гэжээ.

1937-5-4-нд УБХ-ын тэргүүлэгчдийн хурлаар нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

Мөн дүрмийн 4-р бүлэгт

Хот захирах яамны дотоод зохион байгуулалт нь

## Ардын боловсролын хэлтэс

1932 оны 8 дугаар сарын 22-нд Сайд нарын Зөвлөлийн 9 дугаар хурлын 3 дугаар зүйлээр Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг салгаж байгуулахаар шийдвэрлэсэн юм.

1938 оны 04 дүгээр сарын 1-нд СнЗ-ийн хуралаар хот сайжруулах комиссын төслийг хэлэлцээд баталсан.

1939 оны 3 сард улсын 22 дугаар бага хурлын тогтоолоор “хотыг захирах яам” хэмээн нэрлэхийг “Улаанбаатар хотын захиргаа” хэмээн нэрлэх болсон.

1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хуулиар “Улаанбаатар хотын бага хурлын тэргүүлэгчид” хэмээн тогтоосон.

1940-10-3-нд Сайд нарын Зөвлөлийн 50-р хурлын 8-р зүйлээр Улаанбаатар хотын хөдөлмөрчин ардын хурал ба хотын захиргааны дүрмийг баталжээ.

Мөн дүрмэнд хотын захиргааны дотоод зохион байгуулалтыг :

- Ардын гэгээрлийн хэлтэс

1953 онд Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалт, орон тоо нь:

- Гэгээрлийн хэлтэс 1- 9

1952 оны 11 сарын 01-ээс Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа - хэмээх болсон. Бөгөөд дотоод бүтцийг нь : Бүгд 7-123 тус тус байсан байна

1957-7-6-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 104-р зарлигаар үндсэн хуулийн зарим зүйлд өөрчлөлт оруулж аймгийн ба Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргаанд дор дурдсан хэлтсүүд байхаар тогтоожээ. Үүнд:

- Гэгээрлийн хэлтэс

1961-11-24-нд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг:

- Гэгээрлийн хэлтэс

1962 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хэмээх болсон.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс 1965 оны 04 сарын 14-ний өдөр гаргасан 79 дүгээр зарлигаар хороодыг татан буулгаж, Улаанбаатар хотод Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, гэсэн 4 районыг байгуулсан.

1965 оны 06 дугаар сарын 01-нд Сайд нарын Зөвлөлийн 601 дугаар тогтоолоор Улаанбаатар Хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг

- Гэгээрлийн хэлтэс

1965-6-11-нд Сайд нарын Зөвлөлийн 190-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг

- Гэгээрлийн хэлтэс

1968-6-7-нд Сайд нарын Зөвлөлийн 185 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг

- Ардын боловсролын хэлтэс

1975-2-27-нд Сайднарын Зөвлөлийн 104-р тогтоолоор Улаанбаатар хотын захиргааны зохион байгуулалтыг дор дурдсанаар баталжээ.

- Ардын боловсролын хэлтэс

1978-9-11-нд Сайд нарын зөвлөлийн 294-р тогтоолоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орон тоог 102 нэгжээр, зохион байгуулалтыг

- Ардын боловсролын хэлтэс

1989 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн Сайд нарын Зөвлөлийн 152 дугаар тогтоолоор Улаанбаатар Хотын Ардын депутатуудын хурлын Гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг дарга 1, нэгдүгээр орлогч 1, Орлогч дарга 1, /Нийгэм соёл эрхэлсэн, барилгын асуудал эрхэлсэн, орон сууц, нийтийн аж ахуй, хот тохижуулах эрхэлсэн/ хариуцлагатай нарийн бичиг 1 тус тус батласан.

Улаанбаатар хотын Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд

- Ардын боловсролын хэлтэс

1989 оноос өмнө аймаг, хотын хурал, гүйцэтгэх засаглал/ хоёр/ нь нэг даргатай байсан ба 1989 оноос хойш Монгол Улсын аймаг, хотын хурал биеэ даан /орон тооны бус/ даргатай, тэргүүлэгчидтэй болжээ. 1989-1990 Улаанбаатар хотын Ардын Депутатуудын хурлын Тэргүүлэгчдийн хурал 225 депутат, 15 тэргүүлэгчтэй байсан. 1990 оны 01 дүгээр сараас УБХ-ын Ардын хурал гэх болсон. 1990 оны 07 дугар сар хүртэл ажиллаж байсан тэр үед хурал 225 депутат, 15 тэргүүлэгчтэй байв.

Сайд нарын зөвлөлийн 1990 оны 06 дугаар сарын 08-ны 297 дугаар тогтоолоор УБХ-ын АДХГЗ-ны Удирдлагын орон тоог дарга 1, нэгдүгээр орлогч дарга 1, орлогч дарга 4 байхаар тогтоов.

1992 оны 25-р тогтоолыг үндэслэн Нийслэл хотын 4 районыг 6 болгож, Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааг Нийслэл хотын Засаг даргын тамгын газар болгон орон тоо зохион байгуулалтанд доорхи өөрчлөлтийг хийжээ. Үүнд

Төлөөлөгчдийн хурлын ажлын алба гэсэн үндсэн зохион байгуулалтай болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Монгол улсын /шинэ/ Үндсэн хуулийн жаран нэгдүгээр зүйлийн 4, Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн хорин наймдугаар зүйлийн 1, 3 дугаар заалтыг үндэслэн Нийслэлийн Удирдлагын Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 4, Тамгын газрын дарга бөгөөд Засаг захиргааны хэлтсийн дарга 1 байх, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дорь дурьдсан хэлтэс тасагтай байхаар тогтоов.

1992 онд батлагдсан үндсэн хуулиар цоо шинэ бүтэцтэйгээр хуульчлагдсан билээ. Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгийн тавин есдүгээр зүйлд" Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ гэж заасан билээ.

1994 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн Монгол Улсын Их хуралаар "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан.

Улаабаатар хотын Захирагчийн ажлын албаны тухай "Монгол улсын Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг тусд нь зохион байгуулан ажилуулах болсон нь засаг захиргааа, аж ахуйн үйлчилгээний ажлын ялгаа заагийг тогтооход чухал ач холбогдолтой болсон.

Нийслэлийн засаг даргын /ажлын алба буюу/ Тамгын газар нь

Засаг захиргааны хэлтэс

Санхүүгийн хэлтэс

Цэрэг, Иргэний хамгаалалтын хэлтэс

Эдийн засаг, нийгмийн бодлогын хэлтэс

Хянан байцаах хэлтэс

Статистик мэдээллийн хэлтэстэйгээр ажиллаж байв.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 263 тоот тогтоолоор Нийслэлийн Удирдлагыг Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 1, Засаг даргын Тамгын газрын бүтцийг доорхи байдлаар тогтоосон. Үүнд: Төрийн Захирааны удирдлагын хэлтэс

Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс

Нийгмийн бодлогын хэлтэстэй байхаар тогтоосон.

1997 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 246 дугаар тогтоолоор "Гадаад харилцааны хэлтсийг нэмж байгуулсан.

1998 оны 27 дугаар тогтоолоор Статистик мэдээлэл Судалгааны алба, 124 дүгээр тогтоолоор "Архивын алба" 1999 оны 206 дугаар тогтоолоор "Цэрэг Иргэний хамгаалалтын штаб" гэсэн хэрэгжүүлэгч агентлагуудыг байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 11дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтол гарч Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь:

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс

Санхүүгийн бодлогын хэлтэс

Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс

Хууль зүйн хэлтэс Гадаад харилцаа хамтын ажиллагааны хэлтэстэй байхаар тогтоож, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Төрийн захиргааны даргын үүргийг давхар хариуцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 09 дүгээр сарын 08-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор Нийслэлийн Засаг даргын тамгын газрын бүтцийг нь:

Төрийн Захиргаа хууль зүйн хэлтэс

Стратеги бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Цэргийн болон гамшгаас хамгаалах штаб

НЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг 60 хүртэл тогтсон.

2004 оны Засгийн газрын 182 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс / Олон нийттэй харилцах албат

Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Цэргийн штаб

Хууль зүйн хэлтэс

Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс гэсэн 8 хэлтэс 75 хүртэл орон тоотойгоор ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 19-нд 15 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь:

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /олон нийттэй харилцах болон хяналт-шинжилгээ үнэлгээний албатай/

Хотын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн хэлтэс

Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс

Хууль зүйн хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Цэргийн штаб зэрэг 7 хэлтэс 70 орон тоотой баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн "Нийслэлийн Засаг даргын 22 тоот захирамжаар Захирагчийн Ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоосон Захирагчийн ажлын алба н

а/ Инженерийн байгууламжийн хэлтэс

б/ Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс

в/ Хот нийтийн аж ахуйн хэлтэс

г/ Аялал жуулчлалын хэлтэстэйгээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дүгээр сарын 24-нд 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг нь: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын орлогч /Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч /Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч / Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын орлогч Үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан/ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтыг нь

Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Санхүү, төрийн сангийн хэлтэс

Нийгмийн хөгжлийн хэлтэс

Хотын хөгжлийн бодлогын хэлтэс

Үйлдвэрлэлийн хэлтэс

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс

Хууль зүйн хэлтэс

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс

Цэргийн штаб

Хэвлэл, мэдээллийн алба зэрэг 85 орон тоотойгоор баталсан бүтэцээр одоог хүртэл ажиллаж байна.